

Хичээлийн судалгааны үр дүнг тайлагнах илтгэл бичих зөвлөмж

Н.Оюунцэцэг (МХСН-ийн
гүйцэтгэх захирал, МУИС-
ийн ШУС-ийн зөвлөх проф.)

Агуулга

- I. Судалгааны асуудлаа таних, судлах, түгээх
- II. Судалгааны ажилд гаргадаг зарим алдаа
- III. Илтгэлийн хураангуй ба дэлгэрэнгүй бичихэд тавигдах шаардлага
- IV. Илтгэл бичих зөвөлгөө
- V. ТХБ-ын V хурлын илтгэлийн зарим дутагдал




I. Асуудлаа зөв олох, таних

- Бидний өмнө буюу боловсролын тогтолцоо сургууль, багшлахуй ба хүмүүжүүлэхүйд тулгарсан асуудал судалгаа хийх шалтгаан болно.
- Судалгааны асуудлын бүтэц, цар хүрээ, шинж чанар өөр өөр байдаг.
- Асуудлаа зөв тодорхойлбол судалгааны ажлын үр дүн эерэг гарна.
- Асуудал болгон судлагддаг зүйл биш. Иймд нарийвчлан асуулт болгон хувиргах хэрэгтэй

Асуудлыг шийдэх арга замыг олох (шийдэл чухал)

Судалгааны шийдэл, үр дүнг түгээн дэлгэрүүлэх



ЭШ-ий хурал болон
бусад судалгааны
баримт бичиг
(өгүүлэл гэх мэт)



ЭШ-ий сэтгүүл,
хурлын эмхэтгэл⁴

II. Судалгааны ажилд гаргадаг зарим алдаа

- Асуудлыг олж харах, шийдэх арга замыг дэвшүүлэх, тогтоох тал дээр учир дутагдалтай
- Сэдэвтэй холбоотой ухагдахуун, ойлголт, мэдлэгийг шинжлэх ухааны үндэстэй зөв барьж авч чадахгүй
- Цөөхөн арга хэрэглэдэг (гол төлөв асуулга) тул нотолж баталж чадахгүй
- Орчин үеийн тодорхой, шинэлэг судалгааны аргуудыг олж хэрэглэх тал учир дутагдалтай
- Бусдын санааг хуулах гэх мэт ёс зүйн асуудал гаргадаг
- Үр дүнг батлах, нотлох баримт, шалгуур дутуу
- Хүүхдийн хөгжлийн өөрчлөлтийг яаж судалж, илрүүлдэг нь тодорхойгүй
- Судалгааны үр дүнгийн боловсруулалт дутмаг

- Судалгааны үр дүнг хүүхдэд гарсан өөрчлөлтөөр биш зөвхөн багшийн амжилтаар дүгнэсэн (Оны тэргүүний багш болсон г.м)
- Хамтын хичээл гэдгийг дидактикийн, хөтөлбөрийн талаас бодолцохгүй хэт хавтгайруулсан, суралцахуйн үндсэн зорилтоос хазайсан
- Дүгнэлт нь баримт нотолгоонд үндэслээгүй, сэтгэгдлийн шинжтэй, өөрийн болон бусдын гаргасан санаа аль нь болох нь тодорхойгүй, бүх ажил дууссан, ямар ч бэрхшээл, сул тал байхгүй, шууд үр дүнд хүрсэн мэтээр тайлагнасан

Илтгэлийг хэлбэршүүлэх тал дээр гарч буй алдаа дутагдал

- Удирдамжийг хараагүй эсвэл баримтлахгүйгээр илтгэл бичих (формат зөрүүтэй, дипломын ажлын форматтай)
- Илтгэлийн бичвэрт тавигдах шаардлага зөрчигдөх. Ж: Хэт олон хуудастай (энэ жил 72 хуудастай илтгэл ирсэн)
- Шаардлагагүй илүү зүйлс их (header, footer; нүүр хуудас хийх гэх мэт)
- Элдэв ач холбогдолгүй цитат оруулдаг
- Хүний эсвэл интернет дээр байгаа онол мэдээллийг шууд хуулдаг
- Ном зүй, ишлэл буруу, өрөөсгөл
- Илтгэлийн хураангуй ба дэлгэрэнгүйг тус тусад нь бичдэггүй
- Нэр ойлгомжгүй
- Дүгнэлтийг нот олж гаргах чадвар дутмаг
- Гэх мэт

III. Удирдамжийг ойлгож мөрдөх



МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ”
СЭДЭВТ ОНОЛ ПРАКТИКИЙН V БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

ТАНИЛЦУУЛГА

Илтгэлийн төрөл:

- ҮНДСЭН ИЛТГЭЛ
- Хэлэлцүүлэгт илтгэл (Workshop)
- Салбар хуралдааны илтгэл
- Ханын илтгэл

Илтгэл хүлээн авах:

- Хураангуй
- Дэлгэрэнгүй

Хураангуйд тавигдах шаардлага

ИЛТГЭЛИЙН НЭР:¶

Илтгэгч: Овог, нэр, аймаг (нийслэл), сум (дүүрэг), сургууль, утасны дугаар, е-мэйл хаяг¶

Илтгэлийг хамтран боловсруулсан багийн гишүүд: Овог, нэр, аймаг (нийслэл), сум (дүүрэг), сургууль, утасны дугаар, е-мэйл хаяг¶

ХУРААНГУЙ¶

- Зорилго¶
- Судалгааны загвар /арга зүй/ хандлага¶
- Судалгааны үр дүн¶
- Практик ач холбогдол¶
- Шинэлэг тал/санаа¶
- Түлхүүр үг¶
- Товч агуулга: 200-250 үг¶

¶

ИЛТГЭЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

Удиртгал

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар:

- Сэдвийг сонгосон үндэслэл
- Сонгосон судлагдахуун
- Хамрах хүрээ: Хэддүгээр ангийн хэдэн сурагчид хамрагдсан болох, ямар мэргэжлийн хэдэн багш хамрагдсан болох
- Эерэг үр дүн гарахад зарцуулсан хугацаа

Хугацаа:

- Энэхүү судалгааг ямар хугацаанд хийсэн болох

Хэрэгжүүлсэн байдал

- Гол үйл ажиллагаа /Товч: Сурагчдыг хэрхэн хөгжүүлсэн болох, багшийн арга зүй хэрхэн сайжирсан болох, бие биенээсээ хэрхэн суралцсан болох/

Судалгааны үр дүн

- Зорилгодоо хүрсэн байдал: Дээрх үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж чадсан эсэхийг нэгтгэн дүгнэх, үр дүнтэй болсон эсэхийг шинжлэх
- Яагаад сайн болсон бэ?
- Бусдад хүргэх туршлага
- Цаашид хөгжүүлэх санал

Ном зүй

IV. ИЛТГЭЛ БИЧИХ ЗӨВӨЛГӨӨ.

Зөвлөгөө 1. Судалгааны сэдэв сонгох



- Тулгамдсан асуудлыг хөндсөн
- Ойлгомжтой, шинэлэг
- Хүссэн үр дүндээ хүрч болохуйц
- Харьцуулан үнэлэх, тайлбарлах, үндэслэх боломжтой байх
- Судалгааны үр дүн нь үнэ цэнэтэй, ач тустай байх
- Шинэ мэдлэг, шийдэл, арга замыг бүтээсэн байх
- Илтгэлд хэрэглэж буй нэр томьёо бүрийг сайтар ухаарч ойлгох, өөртөө тайлбар хийх шаардлагатай.

Зөвөлгөө 2: Илтгэлийг нэрлэхэд анхаарах (дутагдалтай жишээ):

- Сурагчдын графиктай ажиллах чадварыг **явцын үнэлгээгээр** хөгжүүлэх **арга зүй**
- **100 үгтэй** эхээр бичих чадварыг хөгжүүлэх арга зам
- Үлгэрээр сурагчдын гадаад хэл **сурах сонирхлыг нэмэгдүүлж**, хүнд эхийг **асуултын аргаар ойлгуулах** нь.
- Сурагчдаар эсээ бичүүлж сургах **нэг** алхам
- Техник бүлэг сэдвээр суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх **сургалтын үйл ажиллагаа**.
- **Асуултад хариулах, асуудлыг тайлбарлах чадварыг** хөгжүүлэх нь

Нэрлэсэн сайн жишээ:

- Асуудал шийдвэрлэх арга зүйгээр шинжлэх ухаанч арга барилын түвшинг ахиулах нь
- Өртөөчилсөн аргаар сурагч нэг бүрийг хичээлд жигд оролцуулах нь
- Шилжүүлэгч факторын аргыг химийн бодлого бодох бусад аргуудтай харьцуулан судлах нь
- Сурагчдын графиктай ажиллах чадварыг явцын үнэлгээгээр хөгжүүлэх арга зүй
- 6 настай хүүхдийн гарын жижиг булчинг хөгжүүлснээр бичих чадварыг нэмэгдүүлэх арга зүй

Зөвөлгөө 3. Илтгэлийн авторыг бичих (жишээгээр)

**Суралцагчдын шинжлэх ухаанч арга барилд гарч
буй ахицыг ажлын хуудас ашиглан үнэлэх нь**

Л.Шүр-Эрдэнэ. Shur-Erdene@bsug.or.gov.mn

*Орхон аймаг БСУГ-ын Байгалийн ухааны сургалт, арга зүй хариуцсан
мэргэжилтэн*

**Үлгэрээр сурагчдын гадаад хэл сурах сонирхлыг
нэмэгдүүлж, хүнд эхийг асуултын аргаар ойлгуулах
нь.**

*¹Л.Хажидмаа , ²Б.Тунгалагцэцэг, ³П.Даваадулам, ³Л. Дэнсмаа,
³Ц.Цолмон, ³С.Халиун, ³Л.Мягмарсүрэн, ³Г.Энхцэцэг, ³Б.Мөнхсайхан,
³Д.Баясгалан*

*¹Хөвсгөл аймаг Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн сургалтын менежер
²Гадаад хэлний заах аргын нэгдлийн ахлагч, ³Багш*

Зөвөлгөө 4: Зорилгыг томъёолох

- Асуудлын шийдэл
- Судалгааны бодит үр дүн
- Яг тухайн нөхцөл байдалд бий болгосон зарчим, онол арга зүй
- Боловсруулан туршсан шийдэл
- Сонгосон шийдлийн хувилбарууд
- Эцэслэн боловсруулсан загвар (шийдэл, загварчилагдсан зүйлс)
- Гэх мэт Хүрэх үр дүнгүүд юм.

Жишээ:

1. Сурагчдын сайн мэддэг үлгэрийн үйл явцаас шинэ үгийн утгыг таамаглан ойлгуулж цээжлүүлэх нь хүүхдийн сурах үйл явцад хэрхэн дэмжлэг үзүүлж буйг судалгаат хичээлээр судлан, үр дүнг тооцоход оршино.
2. Уншиж буй эсээний баримт, үзэл бодлын уялдаа холбоо түүний утга агуулгыг задлан шинжлэх замаар сурагчдаар эсээ бичүүлж сургах арга зүй, туршлагаа хуваалцах

Зөвөлгөө 5: Судалгааны загвар /арга зүй/ хандлага

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар:

- Сэдвийг сонгосон үндэслэл
- Сонгосон судлагдахуун
- Хамрах хүрээ: Хэддүгээр ангийн хэдэн сурагчид хамрагдсан болох, ямар мэргэжлийн хэдэн багш хамрагдсан болох
- Эерэг үр дүн гарахад зарцуулсан хугацаа

Хугацаа:

- Энэхүү судалгааг ямар хугацаанд хийсэн болох

Хэрэгжүүлсэн байдал

- Гол үйл ажиллагаа /Сурагчдыг хэрхэн хөгжүүлсэн болох, багшийн арга зүй хэрхэн сайжирсан болох, бие биенээсээ хэрхэн суралцсан болох/
- Хэрэглэсэн гол аргууд

Жишээ: Химийн “Сайн хичээл”-д хийсэн анализын зарим үр дүнгээс

Судалсан баримт бичиг:

- Хичээлийн төлөвлөгөө, химийн сургалтын хөтөлбөр боловсруулсан багийн гишүүдийн санал, дүгнэлт, хичээлд ажиглалт хийсэн ажиглагчдын тэмдэглэл, сайжруулан хэвлэсэн хичээлийн төлөвлөгөө

Хэрэглэсэн арга, аргачлал:

- Суурь боловсролын химийн хичээлийн шинжлэх ухаанч арга барил, тэдгээрийн шалгуур
- Шинжлэх ухаанч арга барилыг төлөвшүүлэх хичээлийн гол онцлог болох сурагчийн оролцох, судлан шинжлэх, тайлбарлах, нарийвчлах, үнэлэх үйлийн шалгуур (5E загвар)
- Шинжлэх ухаанч арга барилд суурилсан байгалийн ухааны хичээлийг үнэлэх рубрикийн арга (Бодзин, Карен Беерер, 2004)

Туршилт судалгааны үйл ажиллагаа

- Хичээлээр ШУАБ-ыг төлөвшүүлэх үйл ажиллагааны тойм анализ
- Хичээлийн төлөвлөлт нь 5E загварын шалгуурыг хангасан байдлын анализ
- Хичээлийг рубрикийн аргаар үнэлсэн

Зөвөлгөө 6: Судалгааны⁸ үр дүнгийн боловсруулалт

- Зорилгодоо хүрсэн байдал: Дээрх үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж чадсан эсэхийг нэгтгэн дүгнэх, үр дүнтэй болсон эсэхийг шинжлэх
- Анализаас гарсан баримт (дата)-ыг боловсруулах
- Тухайн асуудлыг шийдэх бусдад хүргэх арга зам, боломжууд
- Бусдад хүргэх туршлага
- Бас тохиолдож болох бэрхшээл, түүнийг даван туулах арга гэх мэтээр олж мэдсэн, нээсэн зүйлс орно.



- Баримт нотолгоог сайн гаргах.
- Сургалтын үйл явцад ажиглалт хийж, түүнийхээ учир шалтгааны холбоог турших.
- Судалгааны үр дүн шалгагдан батлагдсан байх
- Гарааны төлөв байдлын судалгаа ба эцсийн өөрчлөлтийг илрүүлэх шалгуурыг тодорхойлох
- Тэдгээрийн харьцуулалтаас хүүхдийн хөгжил, өөрчлөлтийн талаар баримт гаргах боломжтой байх.

Зөвөлгөө 7: Цаашид хөгжүүлэх санал

Судалгааны ажил бол цикл процесс

- Аль шатанд судалгаа явагдсан
- Дутагдалтай, бэрхшээлтэй, зөрүүтэй, шийдэгдээгүй зүйл юу байв?
- Цаашид ямар шатыг, яагаад хэрэгжүүлэх
- Юуг нарийвчлан турших эсвэл дэвшин турших, улам сайжруулах
- Гэх мэт ирээдүйн төлөвлөгөө

Зөвөлгөө 8: Дүгнэлт бичих

- Үр дүнг нэгтгэн багцалсан бичвэр
- Баримт дээр суурилж бичнэ
- Нотолгооны гол санааг нэгтгэсэн бичвэр
- Судалгааны танилцуулгын сүүлийн хэсэг
- Нээсэн, сурч мэдсэн зүйлсийн батламж

- Дүгнэлт бичихдээ судалгаандаа суурилах
- Зорилго, зорилт ба дүгнэлт таацах

Зөвөлгөө 9: ЭШЛЭЛ ЗҮҮЛТ, НОМ ЗҮЙ

- Түгээмэл хэрэглэдэг “APA Style”-ийн стандарт,

<http://flash1r.apa.org/apastyle/basics/data/resources/sample-references2.pdf> болон

<http://www.apastyle.org/learn/index.aspx> хаягаас

- Bodzin, B. &. (2004). Promoting Inquiry-Based Science. Нашивел. <https://goo.gl/tRbs0B>. (2016, 11 22). Retrieved from <https://www.google.mn/>: <https://goo.gl/tRbs0B>
- Оюунцэцэг Н., Далайжамц Ц., Нямгэрэл Ч., ба бусад, (2003), Математик байгалийн ухааны багш бэлтгэж буй киррикулимийн төлөв байдалд хийсэн анализ, дүгнэлт//Багш боловсролын хөгжлийн чиг хандлага (стандарт, киррикулимийн онол арга зүй), УБ.,


V. Онол практикийн V бага хуралд ирүүлсэн ТХБ-ын илтгэлийн зарим дутагдал (сэдэв ба зорилго хэсгийн):

- Асуудлыг хэрхэн илрүүлсэн, шийдсэн арга зам тодорхойгүй
- Зорилгын томъёолол оновчтой бус
- Хэт олон давхар асуудлыг судласан
- Нэр хэт олон үгтэй, ойлгомжгүй, найруулга муутай
- Зарим сэдвийн хүрээ хэт том
- Гол төлөв багш нарын санал дээр тулгуурласан, хүүхэд талаас бага анхаарсан
- Судалгааны зорилго ба үр дүн тодорхойгүй, ерөнхий
- Яг ямар чадвар, дадлыг, яаж олгож байгаа нь ойлгомжгүй, тодорхой биш
- Үндсэн ойлголт, нэр томъёоны тайлбар, утга тодорхой бус
- Хүүхдэд ямар өөрчлөлт гарч байгаа зэрэг үр дүнг нотлох баримт хомс
- Гэх мэт

Боломжийн жишээ (зорилго):

- Эх бичиж, мэдээлэл солилцох аргыг ашиглан хүүхэд нэг бүрийн бичих – унших, ярих- сонсох гэсэн хосолсон чадварыг хөгжүүлэх
- Сурагчдад шинжлэх ухааны мэдлэг, чадварыг хэрэглээ болгоход асуудал шийдвэрлэх арга зүй нь хэрхэн дэмжлэг үзүүлж чадаж буйг судалгаат хичээлээр судлах, үр дүнг тооцох
- Математикийн хичээлд тохирсон өртөөчилсөн сургалтын арга боловсруулах, бусдад түгээн дэлгэрүүлэх
- “Үгэн тэгшитгэл дэх бодисын нэрийг томъёогоор бичих арга” сэдвээр хичээлийн судалгаа хийж сайн хичээл бий болгох

ДүГНЭЛТ



- Хичээлийн судалгааны арга зүй бол багшлахуйд тохиолдох бэрхшээлийг шийдэх нэг үндсэн арга зам юм.
- Судлах асуудлаа олж илрүүлж, нарийвчилдаг
- Судалгааны үр дүнд асуудал шийдвэрлэх арга бий болж тухайн асуудал шийдвэрлэгддэг
- Тухайн асуудлыг шийдэх бусдад хүргэх арга зам, боломжууд бусдад хүргэх туршлага бол судалгааны үр дүн болдог
- Судалгааны дүгнэлт баримт нотолгоонд суурилсан байдаг



МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ
MONGOLIAN ASSOCIATION OF LESSON STUDY

2016 оноос

Mals.mn

- БИДНИЙ ТУХАЙ ▾
- СУРГАЛТ ▾
- ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ▾
- ЗӨВЛӨГӨӨ ▾
- СУДАЛГААТ ХИЧЭЭЛ ▾
- ГАДААД ХАРИЛЦАА ▾

"ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ
АРГА ЗҮЙ- 2015" СЭДЭВТ ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГУРАВДУГААР БАГА ХУРАЛ
АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНГӨРЛӨӨ



Эрдэм шинжилгээ

ЗӨВЛӨГӨӨ ▾

ГАДААД ХАРИЛЦАА ▾

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт

"ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ - 2015" СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХОЁРДУГААР БАГА ХУРЛЫН ИЛТГЭЛИЙН ЭМХЭГЭЭЛ

ҮНДЭСНИЙ ЭКСПЕРТ, ЗӨВЛӨХИЙН ХИЧЭЭЛ

ЯПОНЫ ЗӨВЛӨХИЙН ХИЧЭЭЛ

ГАРЫН АВЛАГА

СУДАЛГААТ ХИЧЭЭЛ ▾

БАГА БОЛОВСРОЛ

25

Анхааран сонссонд баярлалаа